

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.12.11-2021.06.12/

2021 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Монгол Улсын хилийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Улсын онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2020 оны 12 дугаар сарын 11-нээс 2021 оны 06 дугаар сарын 12-ны өдрийг дуустал дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны талаар

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд нийт 58 орны 404 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг /нэг удаагийн орох 363, хоёр удаагийн орох 0, олон удаагийн орох 20, нэг удаагийн гарах-орох 15, хоёр удаагийн гарах-орох 0, олон удаагийн гарах-орох 6, дамжин өнгөрөх нэг удаагийн 0/ олгосон бөгөөд визийн шилжүүлэг 0, визийн сунгалт хийгдээгүй байна.

Монгол Улсад түр хугацаагаар ирсэн 13 орны 59 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан 14 орны 69 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийж, мөн оршин суух зөвшөөрөлтэй 30 орны 96 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийсэн.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 2 орны 4 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрлийн газарт хүргүүлсэн. Үүнд: АНУ-2, Япон-2

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт, зөрчил:

Тус газраас явуулах хяналт шалгалтын 2021 оны төлөвлөгөөг боловсруулж энэ оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулахаар төвд хүргүүлсэн байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад Төв аймгийн Эрдэнэ, Баян, Архуст, Баян-Өнжүүл, Сэргэлэн сумдын нутагт үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадаас ажиллах хүч авч ажиллуулдаг 12 аж ахуй нэгж

байгууллага гадаадын 2 орны 38 гадаадын иргэн хамрагдсан ба ямар нэг зөрчилгүй илрээгүй болно.

Виз, бүртгэлийн нэгдсэн сан “ISM” системээр давхардсан тоогоор 58 орны 3145 гадаадын иргэний “F8” мэдээллийг шүүж шалгасан бөгөөд Шведийн Вант Улсын 1 иргэнийг орох виз, визийн зөвшөөрөлгүй орж зөрчлийг илрүүлсэн.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Тайлант хугацаанд төвөөс албадан гаргасан 8 орны 8 гадаадын иргэн /ИБУИНВУ-1, Румын-1, Украин-1, БНФилиппин-1, Австрали-1, БНХАУ-1, Нидерландын Вант Улс-1, Тайланд-1/-ийг Монгол Улсаас албадан гаргах тухай байгууллагын даргын шийдвэрийг хэрэгжүүлж, уг иргэнийг албадан гаргасан талаарх тодорхойлолтыг Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлсэн.

Истанбул-УБ чиглэлийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн тусгай үүргийн нислэгээр орох виз, визийн зөвшөөрөлгүй Шведийн Вант Улсын 1 иргэн ирснийг 2021 оны 03 дугаар 24-ны өдрийн Франкфурт-УБ чиглэлийн нислэгээр буцаасан.

Шүүх, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын талаар

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалтын чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Төсвийн шууд захирагч АЗБХГ-ын дарга З.Даваасүрэн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төсвийн төвлөрүүлэн захирагч ГИХГ-ын дарга Н.Ууганбаяртай 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдөр байгуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Түүнчлэн төрийн захиргааны албан хаагчид 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө тус газрын даргатай 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр байгуулав.

Тус газрын 2021 оны 1 дүгээр сараас 6 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр баталж хэрэгжүүлж ажилласан бөгөөд биелэлтийг мөн сар бүр тооцсон. Мөн архив, албан хэрэг хөтлөлт, сургалтын талаар 2021 онд хийх ажлын төлөвлөгөө, Төв аймгийн Цагдаагийн газартай 2021 онд хамтан ажиллах төлөвлөгөө, 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүллээ. Үүнд:

Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж хүргүүлсэн, боомтод 2021 оны 1, 2 дугаар улиралд ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж батлуулахаар, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж сар бүрийн 01-ний өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс, Захиргаа удирдлагын газарт;

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний 2020 оны жилийн эцсийн биелэлтийг гаргаж 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, төвөөс өгсөн үүргийн дагуу тус газрын албан хаагчдын орон сууцны судалгааг 1 дүгээр сарын 20-нд гарган тус тус хүргүүлсэн.

Тус газрын 2020 оны сургалтын төлөвлөгөө, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлтийг гаргаж төвд 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2020 онд хийсэн ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргав.

Тус газрын албан хаагчдын 2020 оны гүйцэтгэлийн тайланг дүгнэж 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр төвд хүргүүлсэн бөгөөд 22-ны өдөр үнэлгээний багаар үнэлүүлсэн.

Тус газраас 2021 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө болон нийгмийн баталгааг 2021 онд хангах төлөвлөгөөний төслийг боловсруулж газрын даргаар батлуулахаар бэлэн болсон бөгөөд төвийн төлөвлөгөөтэй уялдуулахын тулд батлагдахыг хүлээж байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр тус газрын даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Жендэрийн үндэсний хорооноос зарласан “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аяныг өөрийн газарт зохион байгуулж, гүйцэтгэсэн ажлын талаар Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн;

Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанаас /02/25-ны өдрийн/ гарсан үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн;

2022 онд тус газарт ажиллаж буй хяналтын улсын байцаагч нарт 5 жилийн урамшууллын судалгааг гаргаж Захиргаа, удирдлагын газарт, 2020 онд тус газраас ажлаас халагдсан болон чөлөөлөгдсөн албан хаагчдын судалгааг гаргаж Санхүүгийн хэлтэст тус тус хүргүүлсэн;

Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан тус газраас салбарын болон төрийн шагналаар шагнуулах саналтай 5 албан хаагчийн анкет, тодорхойлолтыг Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн;

Үндэсний статистикийн хороо, Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулсан төрийн албан хаагчдаас үндэсний бичгийн мэдлэгийн тодорхойлох судалгааг тус газрын албан хаагчдаас авах ажлыг зохион байгуулж, тайланг Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн;

Захиргаа, удирдлагын газраас 04 дүгээр сарын 27-ны өдөр 03/18 тоот дотоод албан бичгээр ирүүлсэн байгууллагын “Орон нутаг дахь газрын ажиллах журам” мөн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын төслийг орон нутаг дахь газрууд албан хаагчиддаа танилцуулж, журмын төсөлд нэмж тусгах, өөрчлөх саналыг авч, нэгтгэн хугацаанд нь Захиргаа, удирдлагын газарт хүргүүлж ажилласан.

2.1.2. Хүний нөөц:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 16 /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 9, хүний нөөцтэй холбоотой 7/ тушаал батлан гаргаж, бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцон ажилласан.

Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд цар тахалын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэм, өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан АЗБХГ-ын даргын 2021 оны А/03, А/04, А/07 дугаарын 3 удаагийн тушаалаар ажлын байранд ажиллах албан хаагчдын хуваарийг баталсан.

Байгууллагын даргын 05 дугаар сарын 13-ны өдрийн “Хүний нөөцийн нэгдсэн систем”-ийн баяжилт, мэдээллийн шинэчлэх ажлын явцад хяналт хийх тухай 01-03/09 дүгээр удирдамжийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газар болон Буянт-Ухаа дахь хэлтсийн албан хаагчдын ажил эрхлэлт, цалин хөлс, холбоо барих мэдээлэл, туршлага, ур чадвар, бусад мэдээллийн нэмэлт, өөрчлөлт зэргийг хүний нөөцийн программд оруулан ажилласан.

Байгууллагын даргын 2021 оны Б/48 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд одоо ажиллаж байгаа 18 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 5 /Д.Мөнхчимэг, Д.Ариунтунгалаг, С.Халиун, Т.Нямбаяр, Б.Ариунбилэг/ байна.

Байгууллагын даргын 2021 оны Б/48 дугаар тушаалаар Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан АЗБХГ-ын Буянт-Ухаа дахь хэлтэс нь 11 орон тоотой батлагдсан бөгөөд одоогоор 10 албан хаагч байна.

Байгууллагын даргын Б/77 дугаар тушаалаар тус газрын 2 /Г.Мөнхзаяа, О.Онгоргаан/, Буянт-Ухаа дахь хэлтсийн 4 /Ц.Ганболд, Б.Даваасүрэн, Д.Оюунчимэг, Д.Нямсүрэн/ албан хаагч нарын цалингийн шатлал нэмэгдсэнийг мэдээллийн санд оруулсан.

Тус газар болон Буянт-Ухаа дахь хэлтэст хяналтын улсын байцаагчаар томилогдсон 5 албан хаагч /Л.Батсүх, Ч.Тулгацоодол, Б.Даваасүрэн, Л.Ундрах, Б.Ундармаа/-ийн, төв рүү дэвшин томилогдсон 1 албан хаагч /Т.Соёл-Эрдэнэ/, нас барсан 1 албан хаагч /М.Бат-Өлзий/, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 1 албан хаагч /Б.Ундармаа/ нарын мэдээллийн хасалтыг Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн мэдээллийн санд шивж оруулсан.

2020 онд ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучлан ажилласан тус газрын 1 албан хаагч /хяналтын улсын ахлах байцаагч Б.Цэгмид/-ийг нэгжийн хөдөлмөрийн аваргаар, 1 албан хаагч /жолооч О.Онгоргаан/-ийг ГИХГ-ын Жуух бичгээр, АЗБХГ-ын даргын тушаалаар 3 албан хаагч /виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Б.Болдсүрэн, Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Төгөлдөр, хяналтын улсын байцаагч С.Онгонзаяа/-ийг мөнгөн шагналаар, /ахлах нягтлан бодогч Ц.Энхтуяа/-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Алтан гадас одонгоор шагнагдсан тус тус байна.

2.1.3.Сургалт:

Агаарын замын боомт хариуцсан газраас зохион байгуулсан сургалтын талаар:

ХХЕГ-ын харьяа хилийн 0218 дугаар ангийн шалгагч офицер, ахлагч 123 албан хаагчид “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд хяналтын улсын ахлах байцаагч Б.Цэгмид зохион байгуулсан байна.

Дотоод хэргийн их сургуультай хамтран зохион байгуулж байгаа “Цэргийн анхан шатны мэдлэг олгох” сургалт 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн үргэлжилж байна. Уг сургалтад нийт төрийн захиргааны 17 албан хаагч хамрагдаж байна.

Гадаадын иргэн, харьяатын газраас зохион байгуулсан сургалтад:

Байгууллагаас 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх сургалтад тус газрын 21 албан хаагч хамрагдсан.

Байгууллагаас 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын талаар зохион байгуулсан сургалтад 3 албан хаагч хамрагдлаа.

Байгууллагаас “Төрийн албаны шинэчлэл, ёс зүйн хандлага”, “Харилцааны ёс ба түүнийг бий болгох нь” сэдэвт 2 удаагийн цахим сургалтад тус газрын албан хаагчид бүрэн хамрагдсан.

Захиргаа удирдлагын газар болон гадаад хэлний сургалтын “Дархан-Энх оршихүй” төвтэй хамтран 2021 оны 4 сарын 20-оос 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл зохион байгуулагдаж буй англи хэлний сургалтад тус газраас 10 албан хаагч хамрагдсан байна.

Байгууллагын даргын 2021 оны 01-03/51 дүгээр удирдамжийн дагуу чиглүүлэх сургалтанд хамрагдаж буй 13 албан хаагчийг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газрын үйл ажиллагаа болон “Чингис хаан” ОУАЗБ, “Буянт-Ухаа” ОУАЗБ-ын үйл ажиллагаатай танилцах сургалтыг зохион байгуулсан.

Байгууллагаас 2021 оны 6 дугаар сарын 4-ний өдөр “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” сэдэвт цахим сургалтад тус газрын нийт албан хаагчид бүрэн хамрагдсан.

Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад:

Төрийн албаны зөвлөлөөс 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Төрийн албан дахь бодлогын инноваци-сургамж ба боломж” цахим семинарт, 04 дүгээр сарын 15-нд “Орчин үеийн техник, технологийн чиг хандлага: Виртуал орчинд ажиллах” сэдвээр, 04 дүгээр сарын 22-ны өдөр “Кибер орон зай дахь аюулгүй байдал” сэдвээр зохион байгуулагдсан цахим сургалтуудад тус газрын 1 албан хаагч /Н.Баянмөнх/ хамрагдсан.

2021 оны 04 дүгээр сарын 12-оос 23-ны өдөр хүртэл Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад тус газрын 2 /Н.Баянмөнх, Г.Төгөлдөр/ албан хаагч хамрагдсан.

Удирдлагын академиас зохион байгуулсан “Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл” сэдэвт сургалтад тус газрын захиргааны ахлах мэргэжилтэн Н.Баянмөнх 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдөр цахимаар хамрагдсан.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад тус газар хэлтсийн төрийн захиргааны 17 албан хаагч хамрагдаж гэрчилгээ гардан авсан байна.

2.2 Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсөв болох 421516000 төгрөгийн санхүүжилт орсноос цалин хөлсөнд 228092390 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 56,771,452 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 16,209,078 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган сар бүрийн 5-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 56771452 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 35417100 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 271993506 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Эхний хагас жилийн байлаар хүү торгууль орлого байхгүй бөгөөд визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 40610858 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 2,136,862 төгрөг, байрны түрээс 12,787,650 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно.

Нийт албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 1496000 төгрөгийн витаминжуулалт хийсэн.

2020 оны жилийн эцсийн тооллогоор элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгийн актлах саналаа ГИХГ-ын санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Байгууллагын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан орон тоо 11 албан хаагчаар нэмэгдүүлэн цалингийн төсвийг тооцсон, 2022 оны төсвийн саналыг боловсруулан санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Харилцагч байгууллагуудтай 2020 онд хамтран ажиллах гэрээг дүгнэн акт үйлдсэн бөгөөд 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулсан. 2020 оны санхүүгийн тайлан, татварын тайланг гарган холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас түүврийн аргаар аудит хийн зөвлөмжгүй дүгнэлт авсан.

Бараа материалд 4,000,000 төгрөгийн худалдан авалтыг /Ковид-19 сэргийлэх нэг удаагийн хувцас, хэрэгсэлд/ хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

Газрын 3 тээврийн хэрэгслэлийн улирлын тос тосолгоог хийлгэж, 2 тээврийн хэрэгслэлийг оношлогоог нийт 854000 төгрөгөөр, Соната-7 автомашинд 318,000 төгрөг, Приус-20 автомашинд 682000 төгрөгийн засвар үйлчилгээг тус тус хийсэн болно.

Актлах хөрөнгийн санал болон Хөшгийн хөндий рүү шилжин нүүхтэй холбогдуулан ашиглалтын зардлыг тооцож тус тус төв рүү хүргүүлсэн.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан.

Хөшигийн хөндий дэхь шинэ нисэх онгоцны буудал ашиглалтанд орохтой холбогдуулан интернет сүлжээ болон суурин утас шинээр тавих асуудлаар үүрэн телефон сүлжээ компаниудаас үнийн судалгаа хийж боломжит компанийг сонгосон.

CCNA технологийн талаар судалгаа шинжилгээ, Windows 2016 – Active directory талаар судалгааны ажил хийгдэж дууссан байгаа.

Буянт-Ухаа дахь нисэх онгоцны буудал дээр шинээр цахим төлбөрийн систем бүхий Гэрэгэ киоск үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай интернет сүлжээг шинээр үүсгэж хэвийн ажиллагааг хангаж ажилласан болно.

“Спарк” дотоод програмд нэвтрэх нэр, нууц үгийг ээлж бүр дээр шинэчилж ээлжийн ахлахуудад хүлээлгэж өгсөн.

Байгууллагын бүтэц зохион байгуулалттай холбоотойгоор шинээр албан хаагч захиргааны байранд шилжин ирсэнтэй холбогдуулан сүлжээний утас татаж суурин компьютер тоног төхөөрөмжүүдийг суурьлуулан хэвийн ажиллах боломжийг бүрдүүлсэн.

2021 оны 04 дүгээр сард ГИХГ-ын сүлжээний инженер Э.Ганзориг, С.Пүрэвчулуун нартай Буянт-Ухаа дахь олон улсын нисэх онгоцны буудлын ISM программ дээр тест хийв. Түүнчлэн тус газрын 4 ээлжийн 17 албан хаагчаар 2021 оны 05 дугаар сарын 11-ны өдрөөс 05 дугаар сарын 14-ны өдрийн хооронд Виз зөвшөөрлийн газарт гадаадын иргэний бүртгэл хяналтын нэгдсэн систем “ISM” программ дээр виз олголт хийх үйлдэлийг гүйцэтгүүлж, хугацааг хэмжин үр дүнг баримтжуулж гаргасан.

Тайлант хугацаанд дотоод сүлжээний 15, техник хэрэгслийн 26, нийт 41 дуудлага хүлээн авч засварлан, төвөөс вайбэр болон дискорд програмыг хэрхэн ашиглах талаар заавалчилгаа видео хийж ажилласан байна.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Тайлант хугацаанд 2020 онд үүссэн архивын нэгжийг хүлээн авах хуваарийг энэ оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлан гаргасан. Эхний хагас жилийн байдлаар тус газрын архивт байнга хадгалах 9, түр хадгалах 91 хадгаламжийн нэгж сан хөмрөгийн бүрдүүлэлт хийн хүлээн авсан. Архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2021 оны А/01 дугаар тушаалаар тус газрын баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдсан бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 2-ны өдөр тус комисс хуралдаж тус газарт 2014-2020 онуудад үүссэн баримт бичгийн хугацаанд дүн шинжилгээ хийн, хадгалах хугацаа дууссан баримтуудын устгах хэргийн жагсаалтыг үйлдэж ГИХГ-ын ББНШК-д хүргүүлэхээр ажиллаж байна.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан зэрэг нийт 110 баримт бичгийг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

Агаарын замын боомт хариуцсан газрын бичиг хэрэгт 48 албан бичиг ирснийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 15 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 39 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

2.4.2 Өргөдөл, гомдол:

2021 оны эхний хагаст аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирсэн өргөдөлгүй, албан хаагчдаас 1 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 1 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Хуулийн хугацаа хэтрүүлсэн өргөдөл байхгүй.

Гурав. Хилийн боомт, орон нутгийн шинэчлэл, бүтээн байгуулалтын талаар:

Хөшигийн хөндий дэх шинэ нисэх буудалд албаны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаарлагатай тавилга, тоног төхөөрөмжийг бүрэн байршуулж, өрөөний хананд лазер зүсэлттэй, акустик хавтангаар тохижилтын ажил, байгууллагын лого хийлгэх ажил хийсэн болно.

Дөрөв. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй байдлын талаар:

Тус газрын нийт албан хаагчид 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдөр, мөн сарын 12-аас 23-ны өдөр хүртэл тус газрын эрэгтэй албан хаагчид нийслэлийн 6 дүүрэгт цар тахлаас урьдчилан сэргийлэх, хөл хорионы дэглэм сахиулах зорилгоор эргүүлд гарч үүрэг гүйцэтгэсэн.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд хандаж Агаарын замын боомт хариуцсан газрын болон Буянт-Ухаа дахь хэлтсийн нийт 24 албан хаагчдад 03 дугаар сарын 17-ны өдөр 1 дүгээр тунг, 04 дүгээр сарын 22-ны өдөр Ковид-19 эсрэг вакцины 2 дахь тунг тус тус хийлгэсэн.

Газрын албан хаагчдыг Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс зорилгоор нэг удаагийн маск, хувцас, гар ариутгагч, денутратны спирт, дархлаа дэмжих салимон, аньс, чацарганы шүүс, хувцас ариутгагч дермобактерийн шингэнээр тухай бүр ханган ажиллаж байна.

Албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор С витамин болон D витаминаар хангасан болно.

Тав. Бусад:

Тус газрын 2020 оны тайлангийн хурлыг 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, тайлангийн хугацаанд албан хаагчдын хурлыг нийт 5 удаагийн цахим хурал зохион байгуулсан байна.

Төв газраас зохион байгуулсан цахим хуралд тус газрын албан хаагчид хамрагдаж байгууллагын удирдлагаас үүрэг, чиглэл авч ажиллаж байна.

Төв аймгийн хөшгийн хөндий дэх Чингис хаан олон улсын нисэх буудлын нүүлгэн шилжүүлэх дэд ажлын хэсгийн хуралд АЗБХГ-ын дарга, хяналтын улсын ахлах байцаагч нар 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр, 06 дугаар сарын 11-ны өдөр тус тус оролцсон.

Удирдлагаас өгсөн үүргийн дагуу 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 20-ны өдрийн хооронд тогтоосон хугацаанд виз олгох үйлчилгээг үзүүлж буй эсэхийг шалгаж тус газрын 17 албан хаагчаар Виз зөвшөөрлийн газарт виз бичүүлж хугацааг хэмжин илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулсан болно.

Иргэний нисэхийн ерөнхий газраас 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр цахимаар зохион байгуулсан “Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах, “Буянт-Ухаа” ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нүүлгэн шийлжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн 7 дугаар хуралд газрын дарга З.Даваасүрэн оролцсон.

“Буянт-Ухаа” ОУНБ-ын орон нутгийн хүндэт зочидын танхимд 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Буянт-Ухаа” ОУАЗБ-ын зөвлөлийн хуралд газрын дарга C:\Users\Suar\Desktop\2021 ehni hagas jil.docx З.Даваасүрэн, хяналтын улсын ахлах байцаагч Б.Цэгмид нар оролцсон.

Ээлжийн ахлахууд “Чингис хаан” ОУНБ-ын ерөнхий зохицуулагчийн 10:00 цагийн шуурхай хуралд тогтмол сууж хил хяналтын бусад байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилласан байна.

Байгууллагын хариуцлагатай жижүүрт өдөр бүр 10:00, 16:00 цагт мэдээ өгч ажилласан.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчилах танин мэдүүлэх зорилгоор биечлэн 35, утсаар 104 иргэнд зөвөлгөө мэдээлэл өгсөн байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА: Н.УУГАНБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ДАВААНЯМ

ХЯНАСАН:
АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРЫН ДАРГА З.ДАВААСҮРЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Н.БАЯНМӨНХ